



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/388

Ховд

Мөнгөн урамшуулал олгох тухай.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дахь заалт, аймгийн Төрийн аудитын газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум, байгууллагын 2018 оны төсвийн хэрэгжилтийг хангахад амжилт гаргаж аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлттэй ажилласан Буянт, Дөргөн сумын Засаг дарга нарыг нэг сарын албан тушаалын цалингийн 30.0 хувиар тооцож мөнгөн урамшуулал олгосугай.

2.Дээрхи сумдын санхүүгийн албаны дарга нарыг үндсэн цалингийн 30.0 хувиар тооцож мөнгөн урамшуулал олгохыг Буянт, Дөргөн сумын Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

3.Тус захирамжийн хэрэгжилтийг хангаж мөнгөн урамшуулалыг 2019 оны батлагдсан цалингийн санд багтаан олгохыг төсөв захирагчдад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



D/Zax-A/388-Da

02 01828